

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.004>

Үндэсний аюулгүй байдлыг хангахад гадаад бодлогын стратеги: Тэнцвэржүүлэх стратеги, түүний онолын үндэс

Б.Алтанхүү

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэн

ABSTRACT

This article examines the theoretical foundations of balancing strategies in international relations and their relevance for the security of small states, with particular reference to Mongolia. The study situates the concept of balancing within classical and neo-realist traditions, while also exploring liberal and constructivist perspectives that highlight the agency of small states. It reviews key theoretical approaches—balance of power, balance of threat, and balance of interests—and contrasts them with related strategies such as neutrality, bandwagoning, hedging, and alliance-building. By integrating comparative insights from leading scholars, the article shows that balancing remains a vital framework for small states to navigate geopolitical competition and safeguard sovereignty. Mongolia's foreign policy practice, notably its “third neighbor” policy and multivector diplomacy, reflects a hybrid form of external and soft balancing combined with hedging. The analysis underscores both the academic significance and practical applicability of balancing strategies for ensuring Mongolia's national security in an increasingly complex and uncertain international environment.

Keywords: *Balancing strategy; Hedging strategy; Small state security; Balance of Power; Balance of Threat; Balance of Interests; Mongolia; Third neighbor policy*

ОРШИЛ

Монгол Улсын гадаад орчинд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлтүүд нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, стратегийн агуулга, хэрэгжилтэд гүнзгий нөлөө үзүүлж байна. Тухайлбал, олон улсын эрх зүй, ёс зүй суларч, геополитикийн өрсөлдөөн, бүс нутгийн хурцадмал байдал нэмэгдэж, дэлхийн хүчний хуваарилалт олон тулгуурт хэлбэр лүү шилжиж, шинэ нөлөө бүхий тоглогчид гарч ирж, уламжлалт хүчний харьцаа эрс өөрчлөгдөж байна. Ийм нөхцөлд улс орнууд улам бүр мэдрэмжтэй, уян хатан, олон талт гадаад бодлого явуулах шаардлагатай болж, Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад бодлогын тэнцвэржүүлэх стратеги онцгой чухал ач холбогдолтой болж байна.

Аюулгүй байдлын гадаад орчны өнөөгийн нөхцөл байдал энэхүү тэнцвэржүүлэх стратегийн шаардлагыг улам бүр тодотгож байна. Орос - Украины дайн, Израил - Ираны дайн, Солонгосын хойгийн хурцадмал байдал, Өмнөд Кавказ

дахь зөрчлүүд нь олон улсын харилцаанд хатуу хүчийг ашиглах явдлыг эргүүлэн авчирч, үндэсний аюулгүй байдлыг хангах арга, хэрэгслүүдийг дахин авч үзэхэд хүргэж байна. Олон улсын эрх зүй, институт, хэм хэмжээний нөлөө суларч үүний оронд хатуу болон зөөлөн тэнцвэржүүлэх стратеги нь улс орнуудын аюулгүй байдлаа хангах гол арга, хэрэгсэл болж байгаа нь илэрхий байна. Хоёр их гүрний дунд орших, нээлттэй, ардчилсан, энхийг эрхэмлэсэн орны хувьд Монгол Улсын геополитикийн орон зай нь их гүрнүүдтэй тэнцвэртэй харилцах шаардлагыг бий болгож байна.

Иймд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад бодлогын хүрээнд тэнцвэржүүлэх стратегийн онол, практикийг судлан тодорхойлох, манай нөхцөлд боломжтой хувилбарыг эрж хайх нь зөвхөн академик бус практик хэрэгжилтийн хувьд ч үндэсний аюулгүй байдлын онол, практикт өндөр ач холбогдолтой юм.

Нэг. Жижиг орны аюулгүй байдлын онол, стратеги

Жижиг улс гэж юу вэ гэсэн асуултад олон улсын харилцааны онолд тодорхой хэмжээний хүн ам, эдийн засаг, цэргийн чадавхаас гадна олон улсын тогтолцоонд үзүүлж буй нөлөөллөөс нь хамааран тодорхойлолт өгсөн байдаг¹. Жижиг улсын хувьд үндэсний аюулгүй байдлаа хангахад гадаад орчны өөрчлөлтөд мэдрэмжтэй, уян хатан стратеги шаардлагатай болдог. Реализм, Неореализм, Конструктивизм, Либерализм зэрэг онолууд жижиг улсын байр суурийг харилцан адилгүй авч үзнэ. Гэсэн хэдий ч жижиг улс нь их гүрнүүдийн өрсөлдөөн бүхий аюулгүй байдлын стратегийн орчинд өөрсдийн онцлогт нийцсэн оршин тогтнох, аюулгүй байдлаа хангах стратегийг зайлшгүй хөгжүүлэх сорилттой тулгардаг.

Жижиг улсуудын гадаад бодлогыг олон улсын харилцааны гол онолууд өөр өөр байр сууринаас тайлбарлана. Реализм ба Неореализм жижиг улсыг олон улсын анархист тогтолцоонд хүчний хуваарилалт, аюулгүй байдлын логикт захирагдсан, бодлого тодорхойлох бус, хариу үйлдэл үзүүлэгч оролцогч хэмээн тодорхойлдог (Waltz, 1979; Vital, 1971). Эдгээр онолоор жижиг улс нь их гүрнүүдийн сөрөг бодлогоос урьдчилан сэргийлэх, тэнцвэрийг хадгалах, эсхүл аялдан дагалдсан байдлаар бүрэн эрх, тусгаар тогтнолоо хамгаалах стратеги сонгохоос өөр гарцгүй байдаг.

Харин либерализм болон конструктивизм нь жижиг улсыг илүү идэвхтэй, бүтээлч субъект гэж үздэг. Либерализмын хувьд жижиг улсууд нь олон улсын байгууллага, хамтын ажиллагааны механизмаар дамжуулан ашиг тус хүртэж чаддаг, дүрэмд суурилсан дэг журмыг хамгаалагч олон улсын харилцааны оролцогч юм (Keohane & Nye, 1977). Харин Конструктивизм жижиг улсууд нь үзэл санаа, үнэт зүйл, өөрийн өвөрмөц шинжийн түвшинд гадаад бодлогоо өөрсдөө тогтоогч байж чадна гэж үздэг. Жишээлбэл, Нордикийн орнууд хүний эрх, байгаль орчин, энх

¹ Энэ нэр томъёо нь туйлын биш харьцуулсан ойлголт гэдгийг анхаарах ёстой. Тухайлбал, Монгол Улсыг жижиг улс гэж авч үзэж байгаа нь аюулгүй байдалд нь нөлөөтэй ОХУ, БНХАУ, АНУ-тай харьцуулсан ухагдахуун юм. Түүнээс зарим нэг судлаачид Монгол Улс жижиг улс биш гэсэн байр суурийг илэрхийлдэг бөгөөд энэ нь уг ойлголтыг ямар хүрээнд, ямар өнцгөөс харж байгаагаас ихээхэн хамаарах юм.

тайвны асуудлаар олон улсад «үзэл санааны удирдагч» болж чадсан нь үүний тод жишээ юм (Ingebritsen, 2006).

Онол	Жижиг улсын талаарх байр суурь	Үндсэн ойлголт ба хандлага	Давуу тал	Сул тал
Реализм	Жижиг улс бол хүчгүй, хязгаарлагдмал нөлөөтэй, их гүрнүүдийн бодлогын объект	Олон улсын тогтолцоо бол анархизм; улс орнууд аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах нь гол зорилго	Гадаад бодлого хэрэгжүүлэхэд үүсдэг их гүрнүүдийн дарамтыг бодитой харуулдаг	Жижиг улс зөвхөн идэвхгүй, хариу үзүүлэгч байхаас өөр гарцгүй мэтээр үздэг
Неореализм	Жижиг улс системийн байрлалынхаа дагуу “хязгаарлагдмал үйлдэгч”	Тогтолцооны түвшний тайлбар давамгай; улсуудын үйлдэл нь хүчний хуваарилалтаар хязгаарлагддаг	Стратегийн орчны чухлыг онцолж, “тэнцвэр” хийх оролдлогыг тайлбарладаг	Дотоод хүчин зүйлс, сонголтыг үл тоомсорлодог
Либерализм	Жижиг улс бол хамтын ажиллагаа, институт, дүрмийн дагуу ашиг хүртэгч	Институт, эрх зүй, худалдаа, хамтын ажиллагаа нь энх тайвны үндэс	Жижиг улсуудыг идэвхтэй оролцогч болгон хардаг; дүрэм, олон талт харилцаанд найддаг	Хүчний бодит хязгаарлалтыг дутуу үнэлдэг, их гүрнүүд дүрмийг зөрчвөл сул орхигдож болзошгүй
Констрактивизм	Жижиг улс бол утга агуулга, үнэт зүйлийг бүтээгч, хүлээн авагч	Үзэл санаа, үнэт зүйл, өвөрмөц онцлог нь гадаад бодлогын гол хүчин зүйл	Жижиг улсууд “үзэл санааны удирдагч” байж чадна (Нордикийн орнууд)	Эрчим хүч, геополитикийн бодит хүчин зүйлсийг дутуу үнэлж болзошгүй

Жижиг улсуудын аюулгүй байдлыг хангах онолын чиглэлд Питер Й.

Катценштайн² (1985), Кристин Ингебритсен³ (2006), Дэвид Витал⁴ (1971) нарын бүтээлүүд чухал байр суурь эзэлдэг. Тэд жижиг улсыг дан ганц хүчин чадлаар биш, гадаад стратегийн хувилбарын олон талт байдал, орших нөхцөлтэй нь уялдуулан тайлбарладаг.

Иймээс жижиг улсын аюулгүй байдлын онолууд нь бүгд нэг зүйлийг хүлээн зөвшөөрдөг: жижиг улс өөрийн оршин тогтнолыг хангахын тулд гадаад орчны хүчний динамикт тохирсон стратегийн сонголт хийхээс өөр аргагүй. Энэ онолын логик нь жижиг улс орнуудад хамгийн өргөн хэрэглэгдсэн стратеги болох тэнцвэржүүлэх хандлага руу хөтөлдөг.

Хоёр. Тэнцвэржүүлэх стратегийн онолын үндэс

Тэнцвэр болон стратеги гэсэн ойлголтын утга, үүсэл

“Тэнцвэр” гэдэг нь нийгмийн болон улс төрийн тогтолцоонд тогтвортой, үр ашигтай байдал хадгалагдахын үндэс суурь болдог ойлголт юм. Энэ нь аливаа системд оролцогч талуудын хооронд хүч, нөлөө, үүрэг, боломжийн хувьд тэнцвэртэй байдал тогтсон тохиолдолд тогтолцоо бүхэлдээ тогтвортой ажиллах боломжтойг илтгэнэ. Улс төр, олон улсын харилцаа, аюулгүй байдалд “тэнцвэр” нь аливаа нэг гүрэн, эвслийн давамгайллыг саармагжуулах, бусдын ашиг сонирхол, аюулыг сөрөх хэрэгсэл болж, ялангуяа жижиг, дунд гүрнүүдийн хувьд оршин тогтнолоо хадгалж, аюулгүй байдлаа хангаж үлдэх стратегийн үндэс болдог.

Тэнцвэржүүлэх (balancing) хэмээх ойлголт нь анх олон улсын харилцааны реалист онолд үүсэж, улмаар жижиг болон дунд улс орнуудын аюулгүй байдлын стратегийн судалгаанд чухал байр суурь эзлэх болсон. Энэ нь олон улсын болон үндэсний аюулгүй байдлын хүрээнд их гүрнүүдийн давамгайллыг сөрөх, гадаад орчны эрсдэл, дарамтыг тэнцвэржүүлэх, өөрийн тусгаар тогтнол, дотоод тогтвортой байдлыг хадгалах зорилготой стратегийн хариу үйлдлийг тодорхойлдог. Энэ ойлголт нь онолын хувьд тодорхой түвшинд хөгжиж ирсэн төдийгүй түүнийг бодит нөхцөл байдалд хэрэгжүүлэх шаардлага, хэрэглээ нь улс орнуудын аюулгүй байдлын бодлогод төв байр суурь эзлэх болсон байна. Иймд тэнцвэржүүлэх стратегийг зөвхөн олон улсын харилцааны онол бус, харин практик бодлого

² Peter J. Katzenstein - Америкийн нэрт улс төр судлаач, олон улсын харилцаа болон улс төрийн онолын чиглэлээр мэргэшсэн профессор. Тэрээр жижиг улсуудын аюулгүй байдал, дотоод бүтэц, гадаад орчны уялдаа холбоог тодорхойлсон “Small States in World Markets: Industrial Policy in Europe” (1985) зэрэг бүтээлээрээ алдаршсан. Катценштайн нь институтийн онолыг гадаад бодлого, аюулгүй байдлын судалгаанд нэвтрүүлснээр онолын шинэ хандлагыг бий болгосон бөгөөд түүний ажлууд нь жижиг улсуудын стратегийн сонголтыг ойлгоход үнэтэй хувь нэмэр оруулсан.

³ Christine Ingebritsen - Америкийн улс төр судлаач, Скандинав судлалын мэргэшсэн эксперт. Тэрээр “Small States in International Relations” (2006) хамтын бүтээлдээ жижиг улсуудын гадаад бодлогын идэвх, зөвлөн хүчний нөлөөллийг онолын болон бодлогын төвшинд судалсан. Ингебритсен нь Норд үндэстнүүдийн (Дани, Норвег, Швед гэх мэт) олон улсын тавцан дахь үүргийг хүний эрх, байгаль орчин, энх тайвны асуудлаар тодруулж, жижиг улсууд “үзэл санааны удирдагч” байж чадахыг нотолсон судлаачдын нэг юм.

⁴ David Vital - Их Британийн улс төр судлаач, олон улсын харилцаа, аюулгүй байдлын онолын анхдагчдын нэг. Тэрээр “The Survival of Small States: Studies in Small Power/Great Power Conflict” (1971) бүтээлдээ жижиг улсуудын тогтвортой оршихуй нь стратегийн орчны тогтворгүй байдал, гүрнүүдийн геополитикийн шахалттай хэрхэн уялдаж байдгийг шинжилсэн. Витал нь жижиг улсыг “айдастай амьдрагч” гэж тодорхойлж, тэдний оршин тогтнохын тулд баримтлах бодлого, хязгаарлагдмал сонголтыг бодиполитикийн үүднээс тодорхойлсон нь аюулгүй байдлын судлалд гүнзгий ул мөр үлдээсэн.

боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцын салшгүй хэсэг, аюулгүй байдлын салбарт бодит ач холбогдолтой хандлага хэмээн үзэх боломжтой.

Тэнцвэржүүлэх гэдэг нь энэ тэнцвэрт байдлыг зориуд бий болгох, хадгалах бодлого, арга хэрэгслийн нийлбэр бөгөөд олон улсын аюулгүй байдлын орчинд хүчний,⁵ ашиг сонирхлын,⁶ аюулын⁷ эсрэг чиглэсэн стратегийн хэлбэр болон хөгжсөн. Улс орнууд энэхүү тэнцвэрийг бий болгохын тулд цэргийн хүчээ нэмэгдүүлэх, эвсэл холбоо байгуулах, дипломат тэнцвэр олох, эсвэл эдийн засгийн хувьд бие даасан байдлаа бэхжүүлэх зэрэг арга замыг нийтлэг байдлаар хэрэглэдэг.

Харин “Стратеги” хэмээх ойлголт нь үүсэл хөгжлөөрөө цэргийн ухаан, ялангуяа Сун Цу, К.Клаузевиц зэрэг сонгодог стратегичдын бүтээлээс эхтэй. К. Клаузевиц стратегийг “улс төрийн зорилгоо цэргийн аргаар хэрэгжүүлэх төлөвлөлт”⁸ хэмээн тодорхойлсон бол орчин үеийн онолчид стратегийг илүү өргөн хүрээнд авч үздэг. Тухайлбал, Түүхч Жон Льюис Гэддис стратегийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. “Стратеги гэдэг бол хязгааргүй хүслүүдийг хязгаартай чадамжтай уялдуулах үйл явц” (Gaddis, J. L. 2018). Тэрээр цааш нь хэрэв зорилго чинь бололцооноос чинь хэт давбал, тэрхүү зорилгоо бодит боломждоо тохируулан хасах шаардлага тулгарна гэж онцолжээ. Стратеги гэдэг бол зорилго, хэрэгсэл хоёрыг хооронд нь уялдуулан, тухайн нөхцөл байдалд нийцүүлэн ухаалгаар холбох чадвар юм⁹. хэмээн тодорхойлсон байдаг.

АНУ-ын хуурай замын цэргийн дайны академийн сургалтад стратегийг Х.Р.Яргерийн томъёолсноор ашигладаг. Тэрээр. “Стратеги гэдэг нь үндэсний хүчний бүх хэрэгслийг (улс төр, эдийн засаг, цэрэг, мэдээлэл г.м) уялдаа холбоотой, нэгдмэл байдлаар ашиглан, тодорхой зорилго (ends)-д хүрэх арга зам (ways), хэрэгсэл (means)-ийн оновчтой зохицол юм.”¹⁰ (Yarger, 2006) гэж тодорхойлсон.

Өнөөгийн олон улсын аюулгүй байдлын орчинд стратеги гэдэг нь цэргийн төдийгүй эдийн засаг, дипломат, мэдээллийн үнэт зүйлд суурилсан хэрэгсэл бүхий үндэсний зорилгод хүрэх цогц төлөвлөлт юм. Тэгэхээр үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад бодлогын стратеги гэдэг нь улс орон дэлхийн болон бүс нутгийн өрсөлдөөн, сорилтыг дүгнэн, тухайн нөхцөлд хамгийн оновчтой, уян хатан, үр дүнтэй хандлагыг хэрэгжүүлэх гэсэн оролдлого юм.

Тэнцвэржүүлэх стратеги нь олон улсын аюулгүй байдлын орчинд их гүрнүүдийн өрсөлдөөн, эдийн засгийн шахалт, үнэт зүйлийн зөрчил, стратегийн түншлэл зэрэгт зохистой хариу үйлдэл үзүүлэх боломж олгодог. Тухайлбал, нэг гүрний давамгайллыг сөрөхөд бусад улсууд эвсэл байгуулах, дипломат фронт нээх, эдийн засгийн хамаарлыг бууруулах зэрэг хэлбэрээр тэнцвэржүүлэх алхмууд хийдэг. Иймд тэнцвэр, стратеги гэсэн үндсэн ойлголтуудыг онолын хувьд авч үзэх

⁵ Хүчний тэнцвэр (Balance of Power)

⁶ Ашиг сонирхлын тэнцвэр (Balance of Interest)

⁷ Аюулын тэнцвэр (Balance of Threat)

⁸ Clausewitz (1832/1918). *On War*, Book I, Ch. I, Sec. 24

⁹ Gaddis, J.L. (2018). *On Grand Strategy*, Penguin Press

¹⁰ Yarger, H.R. (2006). *Strategic Theory for the 21st Century: The Little Book on Big Strategy*. Carlisle, PA: Strategic Studies Institute, U.S. Army War College. <https://press.armywarcollege.edu/monographs/60/>

нь энэхүү судалгааны онолын үндэс болох юм.

Тэнцвэржүүлэх стратегийн онолын төрөл, суурь үзэл

Тэнцвэржүүлэх стратеги олон улсын харилцааны онолд хэд хэдэн хувилбараар тайлбарлагддаг бөгөөд тэдгээр нь тухайн орны аюулгүй байдлын орчин, геополитик, дотоод нөөц боломжид тулгуурлан ялгаатай хэрэгждэг.

Тэнцвэржүүлэх стратегийн гол онол, суурь үзэл баримтлал, онолчдын тайлбарыг авч үзье.

1. Хүчний тэнцвэрийн онол (Balance of Power Theory)


Хүчний тэнцвэрийн онол нь олон улсын системийг анарх бүтэцтэй гэж үздэг реализмын үндсэн тулгуур ойлголт бөгөөд суурь үзэл баримтлал нь улс орнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд хүчний хэт төвлөрлийг саармагжуулах, давамгайлал үүсгэхгүй байхыг зорьдог гэсэн санаанд оршино. Кеннет Уолтц¹¹ (1979) энэ онолыг нео-реализмын хүрээнд цэгцэлж, улсууд системийн дарамтад орж, өөрийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд дотоодод цэрэг, эдийн засгийн чадавх болон гадаадад эвсэл холбоонд нэгдэх зэрэг тэнцвэржүүлэх стратеги хэрэглэдэг хэмээн тайлбарласан.

Эндээс дотоод ба гадаад тэнцвэржүүлэлт (Internal and External Balancing) гэсэн хоёр ангилал гарч ирж байгаа юм. К.Уолтцийн тайлбарласнаар дотоод тэнцвэржүүлэлт нь улс өөрийн хүч чадлыг нэмэгдүүлэх, цэргийн хүч, санхүү, технологи зэрэгт анхаардаг бол гадаад тэнцвэржүүлэлт нь эвсэл холбоо байгуулж, бусад улсын тусламж, түншлэлд түшиглэхийг хэлнэ. Жижиг улсуудын хувьд гадаад тэнцвэржүүлэлт илүү өргөн хэрэглэгддэг бол том гүрнүүд дотоод хүчиндээ илүү найдаж тэнцвэрийг бий болгох стратеги баримтлах нь түгээмэл байна.

Судлаачид тэнцвэржүүлэх стратегийг дотоод болон гадаад тэнцвэржүүлэх (Схем 1) хэмээн ангилдаг бол зарим тохиолдолд дотоод, гадаад, зөөлөн тэнцвэржүүлэх хэмээн гурав ангилж үзсэн нь ч байна.

Тэгэхээр хүчний тэнцвэрийн онолын дагуу улс орнууд аюулгүй байдлаа хангах үүднээс аюул учруулж болзошгүй улсыг хязгаарлан тогтоохын тулд эдийн засаг, цэргийн чадавх зэрэг дотоод хатуу хүчээ хөгжүүлэх, эсхүл бусад улстай цэргийн холбоотон болох зэргээр гадаад хүчээ нэмэгдүүлэх замаар дотоод болон гадаад “хатуу тэнцвэржүүлэх стратеги” (Hard balancing) хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнээс арай хожим гарч ирсэн “зөөлөн тэнцвэржүүлэх стратеги” (Soft balancing) нь хүч илүү улсын давамгайлал, нөлөөллийг хязгаарлахын тулд аюулгүй байдал, цэргийн биш харин улс төр, эдийн засаг, дипломатын арга хэрэгслийг амжилттай ашиглах асуудалд төвлөрч, олон улсын институт, эдийн засгийн арга хэмжээ, дипломат тохиролцоо зэргийг өргөн ашигладаг. Өөрөөр хэлбэл зөөлөн тэнцвэржүүлэх стратеги нь хүч илүү улсуудтай дайсагналцахгүйгээр бусад

¹¹ Кеннет Н. Уолтц (Kenneth Waltz) (1924–2013) – Америкийн олон улсын харилцааны нэрт онолч, нео-реализмыг (бүтцийн реализмын) үндэслэгч. Түүний 1979 онд хэвлүүлсэн “Theory of International Politics” ном нь орчин үеийн реалист онолын суурь бүтээлд тооцогддог. Уолтц олон улсын тогтолцоог анарх шинжтэй, гүрнүүд бие даан амьд үлдэхийг эрмэлздэг гэсэн агуулгаар тайлбарласан бөгөөд үүгээрээ тэнцвэржүүлэх (balancing) стратегийн онолын үндсийг тодорхойлсон юм.



Схем 1. Тэнцвэржүүлэх стратегийн хэлбэрүүд¹²

орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар тэдгээрийн аюул учруулах нөлөөг хязгаарлан тэнцвэржүүлэх стратеги юм.

Роберт Пэйп,¹³ Т.В.Паул нарын судлаачид АНУ-ын давамгайллын үед бусад улс орнууд зөөлөн тэнцвэржүүлэлтийн арга хэрэглэж байгааг онцолдог. Энэ стратеги нь илт сөргөлдөөн үүсгэлгүйгээр өөрийн байр суурийг хадгалах, олон улсын системийн тэнцвэрт байдалд хувь нэмэр оруулах арга юм.

2. Аюулын тэнцвэрийн онол (Balance of Threat Theory)

Стивэн Уолт¹⁴ (1987) Уолтцын хүчний тэнцвэрийн онолыг шүүмжлэн хөгжүүлж, «аюулын тэнцвэрийн онол»-ыг дэвшүүлсэн. Тэрээр энд зөвхөн тухайн улсын цэргийн чадавхаас гадна зорилго санаа, газарзүйн ойр байдал, түрэмгийлэл хийх боломж зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой гэсэн. Улс орнууд аюул гэж үзсэн хүчин зүйлийг саармагжуулахад илүү чиглэж, эвсэл холбоо үүсгэх, харилцаагаа зохицуулах, стратегийн хариу арга хэмжээ авах замаар тэнцвэрийг хангах нь аюулыг тэнцвэржүүлэх асуудал юм гээд. Аль нэг улс орон зөвхөн илүү хүчтэй байгаа нь бусад улсын аюулгүй байдалд шууд аюул, эрсдэл учруулах үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн нэг объектив хүчин зүйл биш харин субъектив хүчин зүйл болох санаа сэдэл, боломж бололцооны асуудал учрах аюулыг тодорхойлж, түүнийг тэнцвэржүүлэх шаардлагыг бий болгоно гэжээ. Тухайлбал,

¹² Lenihan, A. T. (2018). *Balancing Power Without Weapons: State Intervention into Cross-Border Mergers and Acquisitions*. Cambridge University Press. <https://www.cambridge.org/core/books/balancing-power-without-weapons/theory-of-nonmilitary-internal-balancing/8313A96078914B586EE27D3A7FD56D5E>

¹³ Роберт А. Пэйп (Robert A. Pape) – Америкийн стратеги судлаач, олон улсын харилцаа, аюулгүй байдлын судалгааны шинжээч. Тэрээр “Bombing to Win” (1996) номдоо цэргийн хүч хэрэглэсний үр нөлөөг онолын төвшинд задлан шинжилж, стратегийн зорилго ба хэрэгслийн зохицлыг тэнцвэртэй авч үзэхийн ач холбогдлыг тодорхойлсон. Түүний ажлууд нь аюулгүй байдлын бодлогод ихээхэн нөлөө үзүүлсэн.

¹⁴ Стивэн М. Уолт (Stephen M. Walt) – Америкийн олон улсын харилцааны нэрт онолч, нео-реализмын хамгаалах (defensive realism) чиглэлийн төлөөлөгч. Тэрээр гадаад бодлогын тайлбарын хүрээнд аюул занал, хүлээн авах аюулын талаарх ойлголтыг онцолж, 1987 оны “The Origins of Alliances” номдоо аюулын тэнцвэржүүлэлт (balance of threat theory)-ийг дэвшүүлсэн нь түүнийг олон улсын харилцааны онолын салбарт онцгой байр суурь эзлэхэд хүргэсэн.

дэлхийн хоёрдугаар дайны дараа Их Британи нь эдийн засгийн хувьд доройтож, геополитикийн хувьд нөлөө нь буурсан бол АНУ нь цэрэг, эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд тэргүүлэх болсон. Гэсэн ч Британи АНУ-ыг аюул гэж үзээгүй бөгөөд харин ч гүн гүнзгий хамтын ажиллагаа үүсгэж, эвсэл (NATO) байгуулан, “тусгай харилцаа”-гаа бэхжүүлсэн байдаг. Канад, АНУ хоёрыг ч энэ тохиолдолд мөн авч үзэх боломжтой. Канадын хувьд АНУ харьцуулахааргүй хүчтэй хэдий ч нийтлэг үнэт зүйл, хамтран ажиллах итгэлцэл, институтын харилцаа зэргээс шалтгаалан АНУ-ыг хэзээ ч аюул гэж хараагүй төдийгүй тэнцвэржүүлэх стратегийг хэрэглээгүй байдаг. Энэ нь зөвхөн хүч чадал биш, харин тухайн улсын зорилго, санаа сэдэл, хамтын ажиллагааны хандлага аюул эсэхийг тодорхойлдог гэсэн Уолтын онолын баталгаа болдог.

3. Ашиг сонирхлын тэнцвэрийн онол (*Balance of Interests Theory*)

Ашиг сонирхлын тэнцвэр хэмээх ойлголт нь олон улсын харилцаанд улс орнууд зөвхөн хүч, эсвэл аюул заналд хариу үйлдэл үзүүлээд зогсохгүй, өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах, тэнцвэржүүлэх зорилгоор стратегийн сонголт хийдэг гэсэн санаанд суурилдаг. Энэ онол нь классик реализмаас илүү нео-либерал институционализм, конструктивист хандлагатай уялддаг бөгөөд Жозеф Най,¹⁵ Роберт Кеохэйн,¹⁶ Барри Бьюзан¹⁷ зэрэг онолчдын бүтээлд өргөн тусгалаа олсон байдаг.

Ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх стратеги нь дараах онцлогтой:

- Улс орнуудын харилцаанд эдийн засаг, улс төр, соёл, үнэт зүйл, хөгжлийн зорилго зэрэг материаллаг бус хүчин зүйлс бодитой нөлөө үзүүлдэг;
- Аюулгүй байдал нь заавал цэрэг-улс төрийн заналхийлэл төдий бус, ашиг сонирхлын зөрчил байж болдог;
- Хүчний болон аюулын тэнцвэрийн логикоос илүү хамтын ажиллагаа, харилцан хамаарал, прагматик харилцаа зонхилдог нөхцөлд илүү тохиромжтой;
- Эдийн засгийн төрөлжилт, бүс нутгийн хамтын ажиллагаа, олон улсын дүрэм журмын дагуух тэнцвэрийг онцолдог.

Дараах хүснэгтэд тэнцвэржүүлэх стратегийг тодорхойлох аюулгүй байдлын онолын үндэс, стратегийн чиг хандлагыг төлөөлөх нэрт онолчдын гол санаа, бүтээл, байр суурийг харьцуулан харууллаа. Эдгээр онолчдын үзэл баримтлал нь тэнцвэржүүлэх стратегийн онолын олон талт байдал, чиглэлийн ялгаа болон

¹⁵ Жозеф С. Най (*Joseph S. Nye*) – Америкийн нэрт улс төр судлаач, олон улсын харилцааны либерал институционализмын төлөөлөгч. Тэрээр “зөөлөн хүч” (*soft power*), “ухаалаг хүч” (*smart power*) хэмээх ойлголтуудыг анх дэвшүүлсэн бөгөөд АНУ-ын гадаад бодлогын шинэтгэл, стратеги төлөвлөлтөд онолын гүнзгий нөлөө үзүүлсэн. Най бол глобалчлал, олон улсын байгууллагын үүргийг онцолдог либерал чиглэлийн гол онолчдын нэг юм.

¹⁶ Роберт О. Кеохэйн (*Robert O. Keohane*) – АНУ-ын олон улсын харилцааны нэрт онолч, либерал институционализмын төлөөлөгч. Тэрээр Жозеф Найгийн хамт “*Power and Interdependence*” (1977) номыг хамтран бичиж, улс орнуудын харилцан хамаарал, институцийн үүргийг онолын төвшинд баталгаажуулсан. Тэрээр реалист хандлагыг шүүмжлэн, олон улсын хамтын ажиллагаа болон институцийн дэг журмыг үнэлдэг.

¹⁷ Барри Бьюзан (*Barry Buzan*) – Британийн улс төр судлаач, аюулгүй байдал судлалын Копенхаген чиглэлийн тэргүүлэх онолч. Тэрээр аюулгүй байдлыг зөвхөн цэргийн хүрээнд бус, улс төр, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин зэрэг таван салбарт авч үзэх хэрэгтэй хэмээн үзсэн. “*Security: A New Framework for Analysis*” (1998) ном нь аюулгүй байдлын ойлголтыг тэлсэн, орчин үеийн суурь бүтээлд тооцогддог.

тэдгээрийг улс төр, аюулгүй байдлын практикт хэрхэн хэрэглэж болохыг илтгэнэ.

*Хүснэгт 1. Тэнцвэржүүлэх стратегийн онолын үндсийг
тавьсан онолчдын харьцуулалт*

Онолч	Хандлага / Онол	Гол ойлголт	Үндсэн бүтээл	Холбогдох агуулга
К. Клаузевиц	Классик реализм	Дайн бол улс төрийн үргэлжлэл	On War (1832)	Стратегийн суурь ойлголт
Кеннет Н. Уолтц	Нео-реализм	Тэнцвэржүүлэх	Theory of International Politics (1979)	Аюулгүй байдлын системийн тайлбар
Стивэн М. Уолт	Хамгаалах реализм	Аюулын тэнцвэржүүлэлт	Origins of Alliances (1987)	Учирч болох аюулын онол
Жозеф С. Най	Либерал	Зөөлөн хүч	Soft Power (2004)	Стратегийн хэрэгслийн төрөлжилт
Роберт О. Кеохэйн	Либерал институционализм	Харилцан хамаарал	Power and Interdependence (1977)	Институтийн үүрэг
Жон Левис Гаддис	Гранд стратеги	Зорилго-хэрэгсэл-нөхцөл	On Grand Strategy (2018)	Стратегийн логик уялдаа
Роберт А. Пэйп	Стратегийн судалгаа	Хүч хэрэглэх ба шахалт үзүүлэх	Bombing to Win (1996)	Цэргийн стратегийн үр нөлөө
Т.В. Паул	Зөөлөн тэнцвэр	Хязгаарлалт	Restraining Great Powers (2018)	Жижиг улс ба том гүрнүүдийн тэнцвэр
Барри Бьюзан	Копенхаген сургууль	Аюулгүй байдал хамруулах (securitization)	Security: A New Framework (1998)	Аюулгүй байдлын өргөтгөсөн ойлголт

Тэнцвэржүүлэх стратеги нь дэлхий дахины нэг тулгуурт, хоёр туйлт, олон тулгуурт гэсэн хүчний бүтэцтэй салшгүй холбогддог. Хоёр туйлт тогтолцоо (жишээ нь, Хүйтэн дайн) дахь тэнцвэржүүлэлт нь харьцангуй ойлгомжтой бол, олон тулгуурт систем дэх тэнцвэржүүлэх стратеги илүү уян хатан, олон чиглэлтэй, төвөгтэй байдлаар илэрдэг. Орчин үеийн АНУ, БНХАУ, Европын Холбоо, ОХУ, Энэтхэг гэх мэт олон тулгуурт дэлхийд улсууд хэд хэдэн чиглэлд зэрэг

тэнцвэржүүлэх шаардлагатай болж байна. Эдгээр хандлагын онолын үндсийг дараах хүснэгтэд харьцуулан харуулж болно.

Хүснэгт 2. Нэг туйлт, хоёр туйлт, олон туйлуурт дэлхийд хэрэгжүүлэх тэнцвэржүүлэх стратегийн жишээ

Онол	Үндсэн санаа	Гол төлөөлөгчид	Жишээ
Хүчний тэнцвэр	Давамгайллыг сөрөх	Кеннет Н. Уолтц	Хүйтэн дайны үеийн НАТО – Варшав
Аюулын тэнцвэр	Аюулын хэмжээгээр хариу үйлдэл үзүүлэх	Стивэн М. Уолт	АНУ-Япон-БНСУ-ын гурвалсан харилцаа
Ашиг сонирхлын тэнцвэр	Хамтын ашиг, сонирхлыг тэнцвэржүүлэх	Жозеф С. Най, Роберт О. Кеохэйн Барри Бьюзан	Монголын олон туйлуурт гадаад бодлого
Зөөлөн тэнцвэр	Цэргийн бус хэрэгслээр нөлөөллийг хязгаарлах	Т.В. Паул, Роберт А. Пэйп	АСЕАН-ы хамтын ажиллагаа
Дотоод / Гадаад	Хүч нэмэгдүүлэх эсвэл эвсэл байгуулах	Кеннет Н.Уолтц	Вьетнам, БНСУ

Монгол Улсын гадаад бодлогын практикт энэхүү стратегийн элементүүд ихээхэн хэмжээгээр тусгалаа олсон бөгөөд тэнцвэржүүлэх стратегийн онолын цогц ойлголтыг бүрдүүлэх нэг гол бүрэлдэхүүн хэсэг болж байна. Эдгээр онолууд нь Монгол Улсын хувьд аюулгүй байдлаа хангахад тэнцвэржүүлэх стратеги хэрхэн онолын үндэслэлтэй хэрэгжих боломжтойг тайлбарлах чухал суурь болох юм.

Хүснэгт 3. Тэнцвэржүүлэх стратегид холбогдох бусад стратегиуд

Бусад стратеги	Тайлбар	Жишээ
Олон улстай нягт харилцаатай байх стратеги (Omni-enmeshment)	Олон оронтой гүн холбоо тогтоож, өөрийгөө бүс нутгийн эсвэл олон улсын системд нэгтгэх	АСЕАН
Тусгаарлах стратеги (Insulation)	Гадаад оролцоог бууруулах буюу бүрэн тусгаарлах замаар хэт их шахалт, нөлөөнд автахгүй байх	Бутан (зарим үед)
Зөөлөн тэнцвэржүүлэх (Soft balancing)	Дүрэм журам, дипломат арга хэрэгсэл болон олон улсын байгууллагыг ашиглан бусдыг хязгаарлах	Монгол, АСЕАН
Стратегийн хувьд нийцтэй байх чиглэл баримтлах (Strategic alignment)	Бүрэн холбоотны харилцаа бус, тодорхой асуудалд чиглэсэн сонгомол түншлэл байгуулж хамтрах	Энэтхэгийн сүүлийн үеийн бодлого

Тэнцвэржүүлэх стратеги ба бусад стратегиуд

Олон улсын аюулгүй байдлын орчинд улс орнууд үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд олон төрлийн стратеги ашиглаж байна. Эдгээр нь тухайн орны гадаад орчин, дотоод чадавх, түүхэн туршлага, геополитик болон эрх баригчдын сонголтоос хамааран ялгаатай байдаг. Тэнцвэржүүлэх стратеги нь тэдгээрийн дунд харьцангуй төвийг сахисан, уян хатан, тодорхой нөхцөлд оновчтой хувилбар болж чаддаг ч зарим тохиолдолд бусад стратегиудтай давхцах, уялдах, хослох шинжтэй байдаг.

Энэхүү хэсэгт бид тэнцвэржүүлэх стратегийг дараах гол стратегиудтай харьцуулан авч үзлээ.

1. Төвийг сахих стратеги (Neutrality)

Зорилго: Зөрчилд аль нэг талд орохгүй, сөргөлдөөнөөс ангид байх

Арга хэрэгсэл: Үндсэн хуульд тусгах, олон улсын эрх зүйн статустай болох, гадаад бодлогын мэдэгдэл хийх

Давуу тал: Хөндлөнгийн оролцоогүйгээр дотоод тогтвортой байдал, гадаад тэнцвэрээ хадгалах боломж

Сул тал: Стратегийн идэвхгүй байдал, баталгаагүй статустай байх эрсдэл

Жишээ: Швейцар, Туркменистан

2. Аялдан дагалдах стратеги (Bandwagoning)

Зорилго: Давуу хүчинд дагаар орж, аюулаас сэргийлэх, ашиг тус хүртэх

Арга хэрэгсэл: Холбоотны гэрээ, улс төр-эдийн засгийн хамаарал

Давуу тал: Богино хугацаанд аюулгүй байдлыг хангах, ашиг хүртэх

Сул тал: Бие даасан байдлаа алдах, стратегийн золиос бий болох

Жишээ: Доминикан (1965), Монгол (1920–1990 онуудад)

3. Хеджинг стратеги (Hedging)

Зорилго: Болзошгүй аюулыг сөрөхийн зэрэгцээ боломжит ашигт нээлттэй байх

Арга хэрэгсэл: Давхар бодлого, олон талт харилцаа, стратегийн түншлэл ба зөөлөн тэнцвэр

Давуу тал: Уян хатан байдал, бодлогын олон хувилбартай үлдэх

Сул тал: Тодорхой бус мессеж, итгэлцэл буурах эрсдэл

Жишээ: БНСУ, Сингапур, Вьетнам

4. Эвсэл холбоонд нэгдэх (Alliance-forming)

Зорилго: Нэгдмэл хүчээр аюулыг сөрөх, ашиг сонирхлыг хамгаалах

Арга хэрэгсэл: Цэрэг-улс төрийн гэрээ, батлан хамгаалах хэлэлцээр

Давуу тал: Хамтын хамгаалалт, стратегийн дэмжлэг

Сул тал: Эвслийн хатуу бүтэц, нэгдмэл шийдвэрт хүлэгдэх

Жишээ: НАТО, SEATO, АНУ-Япон-БНСУ холбоо

*Хүснэгт 4. Дээрх стратегиудыг тэнцвэржүүлэх
стратегитай харьцуулсан хүснэгт*

Стратеги	Зорилго	Арга хэрэгсэл	Давуу тал	Сул тал	Жишээ
Тэнцвэржүүлэх	Давамгайллыг сөрөх	Дотоод ба гадаад чадавх, эвсэл, дипломат арга	Уян хатан, олон хувилбартай	Давхар дарамтад орох эрсдэл	Вьетнам, БНСУ
Төвийг сахих	Сөргөлдөөнөөс ангид байх	Эрх зүйн статус, төвийг сахисан мэдэгдэл	Хөндлөнгийн байдал	Идэвхгүй, хамгаалалт сул	Швейцар
Аялдан дагалдах	Аюулаас сэргийлэх, ашиг хүртэх	Холбоо, хамаарал	Ашиг хүртэх боломж	Хараат байдал, стратегийн эрх чөлөө алдагдах	Монгол (1921–1990)
Хеджинг	Эрсдэл удирдах, ашиг хослуулах	Давхар буюу зэрэгцээ бодлого, олон чиглэлт хандлага	Уян хатан, боломж бүрдүүлэх	Итгэлцэлд сэв суух, ойлгомжгүй мессеж өгөх магадлал	Сингапур, Монгол (одоогийн)
Эвсэл холбоонд нэгдэх	Нэгдмэл хүчээр аюулыг сөрөх, ашиг сонирхлыг хамгаалах	Цэрэг-улс төрийн гэрээ, батлан хамгаалах хэлэлцээр	Хамтын хамгаалалт, стратегийн дэмжлэг	Эвслийн хатуу бүтэц, нэгдмэл шийдвэрт хүлэгдэх	НАТО, СЕАТО, АНУ-Япон, БНСУ-ын гурвалсан эвсэл

Энэ хэсэгт хийсэн харьцуулалт нь Монгол Улсын хувьд аюулгүй байдлыг хангах гадаад бодлогын стратегия хэрхэн оновчтой тодорхойлох, ямар стратегийг ямар нөхцөлд ашиглах талаар онол-практикийн суурь ойлголтыг бүрдүүлэх юм.

Эндээс харахад тэнцвэржүүлэх стратеги нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангах гадаад бодлогын суурь онолын үндэс болох нь тодорхой болж байна. Түүнчлэн бусад стратегиудтай харьцуулахад тэнцвэржүүлэх стратеги нь бодлогын уян хатан байдал, олон чиглэлд хандсан дипломат ажиллагааг шаарддаг бөгөөд Монгол шиг аюулгүй байдлын хувьд эмзэг улсын хувьд геополитикийн нөлөөнөөс хэт хамаарал үүсгэхгүй байх, өөрийн тусгаар тогтнол, бие даасан байдлыг хадгалах оновчтой арга зам болох юм. Цаашид бодлогын түвшинд энэ стратегийг

улам боловсронгуй болгож, олон улсын туршлага, шинэ сорилт, нөхцөл байдалд уялдуулан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Монгол Улсын хувьд уламжлалт тэнцвэржүүлэх стратеги нь гуравдагч хөршийн бодлого, олон тулгуурт гадаад бодлогын хэлбэрээр хэрэгжиж ирсэн бөгөөд үүнийг онолын хувьд зөөлөн тэнцвэржүүлэлт, гадаад тэнцвэржүүлэлт, хеджинг стратегийн хослол гэж тайлбарлах боломжтой юм. Тэнцвэржүүлэх стратеги нь жижиг улсуудын хувьд үндсэн хамгаалах арга хэрэгсэл байсаар ирсэн боловч, олон тулгуурт системийн өнөөгийн тодорхойгүй байдалд заримдаа хангалтгүй болох тохиолдол байна. Ийм нөхцөлд улсууд зөвхөн тэнцвэржүүлэхээс гадна илүү уян хатан, давхар бодлого бүхий хеджинг стратеги хэрэглэх шаардлагатай болж байна.

Гурав. Хеджинг стратеги¹⁸: Онолын үндэслэл ба агуулга

Олон улсын харилцааны онолын хүрээнд хеджинг буюу эрсдэлийг бууруулах стратеги нь улс орон аливаа том улсын эсрэг бүрэн тэнцвэржүүлэх буюу аялдан дагах стратегийг аль нэгийг нь тууштай сонголгүйгээр, бүх талтай харилцааг эергээр хадгалахыг эрмэлзэхийн сацуу, болзошгүй сөрөг нөхцөлд бэлтгэлтэй байх, стратегийн уян хатан байдлаа хамгаалахыг зорьдог стратеги юм. Уг стратегийн зорилго нь геополитикийн өрсөлдөөн, тодорхойгүй байдал ихтэй орчинд улс орон өөрийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжлийн боломжоо хадгалах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

Судлаачид хеджинг стратегийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Гох (2005, 2007) уг стратегийг “аль нэг талын эсрэг зогсох эсвэл дэмжихийн оронд сонголтыг аль болох хязгаарлахгүй байх, олон хувилбарт нээлттэй үлдээх зорилготой бодлогын багц” хэмээн тодорхойлсон бол, Куик (2008, 2020) улс орнууд хеджинг стратегийг эрсдэлийг сааруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, стратегийн бие даасан байдлаа хадгалах зорилгоор хэрэгжүүлдэг хэмээн тайлбарладаг. Харин Лим болон Күүпер (2015) энэ хандлагыг эдийн засгийн хувьд идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлж буй ч, аюулгүй байдлын хувьд хэт хараат байдалд орохгүй байхыг эрмэлздэг хосолсон бодлого хэмээн тодорхойлсон байна.

Хэдийгээр хеджинг нь зарим талаараа *balancing* (тэнцвэржүүлэх) болон *bandwagoning* (дагах) стратегийн элементүүдийг агуулж байгаа боловч эдгээрээс ялгаатай нь аль нэгийг онцгойлон сонгохгүй, харин хамтын ажиллагаа ба болгоомжлолыг зэрэг хослуулдаг, илүү нарийн тэнцвэртэй стратеги юм. Тэнцвэржүүлэх нь тухайн улсын эсрэг хүч нэмэгдүүлэхийг зорьж, сөргөлдөөнт шинжтэй байдаг бол аялдан дагалдах нь хүчирхэг талд дагаж орж, ашиг хүртэх эсвэл хохирлоос зайлсхийхийг эрмэлздэг. Харин хеджинг нь аль алиныг бүрэн хэрэгжүүлэхгүйгээр, стратегийн сонголтоо нээлттэй, уян хатан байлгах замаар өөртөө ашигтай нөхцөлийг бүрдүүлдэг.

¹⁸ *Хеджинг стратеги (Hedging strategy) - Hedging буюу эрсдэлийг бууруулах стратеги гэдэг нь улс гүрнүүдийн дунд нэгийг нь тууштай сонгон дагахын оронд бүх том гүрэнтэй эерэг харилцааг хадгалахыг эрмэлздэг боловч үүний зэрэгцээ хэт хамаарал үүсэхээс сэргийлэх, хамгийн муу хувилбарт бэлдэх зэрэг урьдчилан сэргийлэх алхмуудыг авч хэрэгжүүлдэг стратеги юм. Гол онцлог шинжүүдэд: хосолсон хандлага: идэвхтэй харилцаа + сөрөг хувилбарт бэлтгэлтэй байх; аль нэг талын дургүйцлийг өдөөхөөс зайлсхийдэг; сул талыг багасгаж, уян хатан байдлыг нэмэгдүүлдэг; хамтын ажиллагаа ба болгоомжлолыг хослуулдаг.*

Монгол Улсын гадаад бодлогын олон тулгуурт хандлага, тэр дундаа “гуравдагч хөрш”-ийн бодлого нь тодорхой хэмжээнд хеджинг стратегийн элементүүдийг агуулж байна гэж үзэх боломжтой. Монгол Улс хоёр хөрш болох Орос, Хятад улстай найрсаг, иж бүрэн стратегийн түншлэлийн түвшний харилцаа тогтоосон бөгөөд үүний зэрэгцээ АНУ, Япон, Европын холбоо зэрэг гуравдагч хөршүүдтэй эдийн засаг, боловсрол, аюулгүй байдал зэрэг олон салбарт хамтын ажиллагаа өрнүүлж байгаа нь гадаад бодлогын олон чиглэлт, хэт хамаарлаас зайлсхийх, болзошгүй эрсдэлд бэлтгэх бодлого хэрэгжиж буйг илтгэж байна.

Хеджинг стратеги нь олон улсын системийн эрх мэдлийн шилжилтийн үед стратегийн тодорхой бус байдалтай нүүр туулж буй улс орнууд, ялангуяа хоёрдогч буюу жижиг улсуудад улам чухал стратеги болж гарч ирж байна. Кэй Когагийн судалгаанд хеджинг нь тэнцвэржүүлэх болон аялдан дагалдах стратегийн хоорондох гурав дахь хувилбар хэмээн тодорхойлсон нь онцлог. Хеджинг нь тодорхой нэг талд бүрэн нийлэхээс зайлсхийж, олон талт, заримдаа зөрчилтэй бодлого хэрэгжүүлэх замаар стратегийн хоёрдмол байдлыг хадгалах, эрсдэлээ тараан байрлуулах, улс төрийн уян хатан байдлаа хадгалах зорилготой стратеги гэжээ. Энэхүү стратеги нь олон тулгуурт байдал руу шилжиж буй үед, магадгүй эрсдэл өндөртэй сонголтуудаас зайлсхийхэд илүү тохиромжтой хувилбар болдог.

Кога хеджингийн стратегийг цэрэг, эдийн засаг, дипломат гурван чиглэлээр авч үзэх зургаан төрлийн хэв маяг бүхий системчилсэн хүрээг санал болгосон. Үүнд: (1) уламжлалт хеджинг (цэргийн тэнцвэржүүлэлт/эдийн засгийн даган нэгдэх), (2) зөөлөн хеджинг (дипломат тэнцвэржүүлэлт/эдийн засгийн даган нэгдэх), (3) аюулгүй байдлын хеджинг (цэргийн даган нэгдэх/дипломат тэнцвэржүүлэлт), (4) эдийн засгийн хеджинг (эдийн засгийн тэнцвэржүүлэлт/цэргийн даган нэгдэх), (5) дипломат хеджинг (эдийн засгийн тэнцвэржүүлэлт/дипломат даган нэгдэх), (6) улс төр-цэргийн хеджинг (цэргийн тэнцвэржүүлэлт/дипломат даган нэгдэх) орно. Эдгээрт цэрэг, эдийн засгийн бодлого нь гол үзүүлэлт болох бөгөөд дипломат үйл ажиллагаа нь тодорхой бус байдалд дүн шинжилгээ хийх хоёрдогч үзүүлэлт болж өгдөг. Хеджинг нь энгийн хосолсон бодлого бус, харин шийдвэр гаргах тодорхой бус нөхцөлд эрсдэлийг удирдах ухаалаг стратеги юм.

Японы гадаад бодлогын туршлагад тулгуурлан Кога Японы Хятадын эсрэг стратегийг хеджинг гэж дүгнэжээ. Хятадын эсрэг цэргийн чадавхаа үе шаттайгаар нэмэгдүүлж, бүс нутгийн холбоотнуудаа тэлж, АНУ-тай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсэн нь үүнийг нотолж байна. Харин АНУ-тай харилцах харилцаандаа Япон нь 1997–2005 болон 2010 оноос хойших аюулгүй байдлын хеджингийн жишээг харуулсан. Эдгээр үед АНУ-ын амлалтад эргэлзэх болсноор Япон өөрийн цэргийн эрх зүйн хязгаарлалтыг сулруулж, бүс нутгийн аюулгүй байдлын сүлжээнд идэвхтэй оролцох болсон юм. Ийнхүү хеджингийн стратеги нь хүчирхэг холбоотонтой байсан ч улс өөрийн бие даасан байдлыг баталгаажуулах стратегийн чухал хэрэгсэл болж өгдгийг харуулж байна.

Монгол шиг харьцангуй жижиг улсын хувьд энэ шинэчлэгдсэн хеджингийн ойлголт нь стратегийн орон зай, олон тулгуурт орчинд өвөрмөц байр сууриа

хадгалах гол хэрэгсэл болохыг харуулж байна. Когагийн загвар хеджинг стратегийг сул дорой байдал бус, харин бодлоготой, ухаалаг, бүтцийн шаардлагаас урган гарсан стратеги гэдгийг харуулж байгаа нь онцлог юм. Ийм стратеги нь Монгол Улсад Хятад, Орос, гуравдагч хөршүүдийн хооронд стратегийн тэнцвэрийг хадгалах, аюулгүй байдлаа хангасан гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд оновчтой суурь болох юм.

Иймээс хеджинг стратеги нь жижиг улсын хувьд зөвхөн онолын үзэл санаа бус, бодит хэрэгцээ болж байна. Монгол Улсын гадаад бодлогын олон тулгуурт чиг хандлага, гуравдагч хөршийн бодлого нь тэнцвэржүүлэх ба хеджингийн хослолыг илэрхийлж байгаа нь тодорхой болж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад тэнцвэржүүлэх стратеги нь олон улсын харилцааны онолд төдийгүй жижиг улс орны бодлогын практикт хамгийн чухал суурь ойлголтуудын нэг хэвээр байна. Хүчний тэнцвэр, аюулын тэнцвэр, ашиг сонирхлын тэнцвэр зэрэг онолууд нь жижиг улс орнуудын тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангахад олон талт боломж, хувилбаруудыг санал болгодог бөгөөд Монгол Улсын хувьд эдгээрийн элементүүдийг уян хатан байдлаар хослуулан хэрэгжүүлж ирсэн байна.

Монгол Улсын гадаад бодлогын гол тулгуур болсон “гуравдагч хөршийн бодлого”, олон тулгуурт чиг баримжаа, энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг нь зөөлөн болон гадаад тэнцвэржүүлэх стратегийн илэрхийлэл юм. Үүний зэрэгцээ, эрсдэлийг тараан байршуулах, ашиг боломжийг хослуулах хеджингийн стратеги ч Монголын гадаад бодлогын хэрэгжилтэд тодорхой хэмжээгээр шингэсэн байна. Энэ нь Монгол Улс хоёр хөршийн геополитикийн нөлөөлөлд автахгүйгээр бие даасан байдлаа хадгалах, олон улсын тавцанд өөрийн байр суурийг баталгаажуулах оновчтой арга зам болж байна.

Практик талаасаа энэхүү стратегийн хэрэгжилт нь Монгол Улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн харилцааг төрөлжүүлэх, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлдэг. Гэвч геополитикийн эрсдэл, хөрш гүрнүүдийн шахалт, дотоодын нөөцийн хязгаар зэрэг сорилтуудыг тооцоолон, тэнцвэржүүлэх стратегийг илүү тодорхой, бодлогын түвшинд хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Цаашид судалгааны түвшинд тэнцвэржүүлэх стратегийн онолын боловсруулалтыг гүнзгийрүүлж, жижиг улсын туршлагаудыг харьцуулан судлах, Монгол Улсын хувьд шинэ нөхцөл байдалд (Орос-Украины дайн, АНУ-БНХАУ-ын өрсөлдөөн, олон тулгуурт системийн шилжилт) хэрхэн хэрэгжүүлэхийг бодит жишээн дээр шинжлэх нь чухал байна. Энэ нь зөвхөн академик ач холбогдолтой төдийгүй үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулахад шууд хэрэглэгдэхүйц практик ач холбогдолтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он
3. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал 2011 он
4. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028
5. Buzan, B., Wæver, O., & de Wilde, J. (1998). *Security: A new framework for analysis*. Boulder, CO: Lynne Rienner.
6. Gaddis, J. L. (2018). *On grand strategy*. New York: Penguin Press.
7. Ingebritsen, C. (2006). *Scandinavia in world politics*. Lanham, MD: Rowman & Littlefield.
8. Katzenstein, P. J. (1985). *Small states in world markets: Industrial policy in Europe*. Ithaca, NY: Cornell University Press.
9. Keohane, R. O., & Nye, J. S. (1977). *Power and interdependence: World politics in transition*. Boston: Little, Brown.
10. Nye, J. S. (2004). *Soft power: The means to success in world politics*. New York: PublicAffairs.
11. Pape, R. A. (1996). *Bombing to win: Air power and coercion in war*. Ithaca, NY: Cornell University Press.
12. Paul, T. V. (2018). *Restraining great powers: Soft balancing from empires to the global era*. New Haven, CT: Yale University Press.
13. Vital, D. (1971). *The survival of small states: Studies in small power/great power conflict*. London: Oxford University Press.
14. Walt, S. M. (1987). *The origins of alliances*. Ithaca, NY: Cornell University Press.
15. Waltz, K. N. (1979). *Theory of international politics*. Reading, MA: Addison-Wesley.
16. Yarger, H. R. (2006). *Strategic theory for the 21st century: The little book on big strategy*. Carlisle, PA: Strategic Studies Institute.